



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

“Ай трейд ҮЦК” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд
брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 63 дугаар зүйлийн 63.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ай трейд ҮЦК” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Компанийн оноосон нэрээс “ҮЦК” тэмдэглэгээг хасуулж, үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхийг “Ай трейд ҮЦК” ХХК /Б.Отгонсүрэн/-д гүүрэг болгосугай.

3. “Ай трейд ҮЦК” ХХК-ийн харилцагчийн үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн болон арилжааны үйл ажиллагаатай холбоотой холбогдох баримтыг өөрийн архивт хүлээн авахыг “Арилжааны төлбөр тооцоо” ХХК /О.Эрдэнэгэрэл/-д, “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д тус тус гүүрэг болгосугай.

4. “Ай трейд ҮЦК” ХХК-ийн тусгай зөвшөөрөл хүчингүй болсонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авах, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлт хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН